

“Харилцаа холбооны ажил”

Хөдөлмөр хамгаалал эрүүл ахуйн чухал цэгүүд

Цахилгаан багажийг ажиллуулах

(1) Цахилгаан хөрөө




Хамгаалалтын каск	Хамгаалалтын каскыг зөв өмс.
Хамгаалалтын шил	Хамгаалалтын шил ба аюулгүйн нүдний шилийг зүү.
Чичиргээг хянадаг бээлий	Чичиргээний тэсвэртэй бээлий өмс.
Хамгаалалтын гутал	Удаан эдэлгээтэй, хальтирдаггүй хамгаалалтын гутал өмсөөрэй.
Хувцас	1. Улирал ба цаг агаартай тохируулж дулаан хувцас өмсөөрэй. 2. Өөрийн биед тохирсон хувцас өмсөж, эмжээрийг сайтар бэхлээрэй. 3. Дулааныг сайн тусгаарладаг бээлий, оймс, бусад зүйлүүдийг өмс. 4. Шархдахаас сэргийлсэн хамгаалалтын хувцас өмс.
Чихний бөглөө	Чанга дуу чимээнээс сэргийлэхийн тулд чихний бөглөө ба чихний хамгаалалт зүү.
Тусгай боловсрол	Цахилгаан хөрөөний ажлыг "Цахилгаан хөрөөний ажилчдад зориулсан тусгай сургалт" авсан хүн л хийнэ.

(2) Хадуурын машин



Хамгаалалтын каск	Хамгаалалтын тагийг зөв өмс.
Хамгаалалтын шил	Хамгаалалтын шил (хамгаалалтын нүдний шил) ба аюулгүйн нүдний шилийг зүү.
Бугуйн хамгаалалт	Бугуйн хамгаалалт зүү.
Чичиргээг хянадаг бээлий	Чичиргээг хянадаг бээлий өмс
Хамгаалалтын гутал	Удаан эдэлгээтэй, хальтирдаггүй хамгаалалтын гутал өмсөөрэй.
Чихний бөглөө	Чанга дуу чимээнээс сэргийлэхийн тулд чихний бөглөө ба чихний хамгаалалт зүү.
шүгэл	Харилцах болон дохио өгөхдөө байнга шүгэл хэрэглээрэй.
Шилбэний хамгаалалт	Шилбэний хамгаалалтыг зөв хэрэглэ.
Аюулгүй байдал ба эрүүл мэндийн боловсрол	Хадуурын машиныг ажиллуулах тухай аюулгүй байдал ба эрүүл мэндийн боловсрол эзэмшсэн хүн

(3) Зөөврийн дугуй хөрөө



Анхаарах ёстой зүйл

1. Гэмтээгүй юмуу эсвэл эрэг шураг нь сулраагүй ир ашигла.
2. Хатуу кабелийн утас болон газардуулгын гэмтлийг шалга.
3. Хамгаалах тагийн нөхцөл ба тоормозны үр дүнтэй байдлыг шалга.
4. Тогтвортой ажлын тавцан дээр ажилла. Гартаа зөөврийн дугуй хөрөөтэй ажил бүү хий.
5. Элэгдсэн бээлий өмсөхийг хориглоно.
6. Хэрвээ зөөврийн дугуй хөрөөг ажиллуулж байхад хэвийн бус дуу чимээ гарвал ажлаа зогсоогоод шалга.
7. Ир нь эргэж байхад дугуй хөрөөг бүү хөдөлгө.
8. Ажлыг эхлүүлэхээс өмнө кабелийн байрлалыг шалга.

(4) Чичиргээт багажууд (замын индүү, чичиргээт өрөм гэх мэт.)

Замын индүү, чичиргээт өрөм гэх мэт чичиргээт багажууд нь гар, хуруу, шуу бадайрах, чичрэх, хөших шалтгаан үүсгэдэг.




Анхаарах ёстой зүйл

1. Чичиргээт багаж ажиллуулах тухай аюулгүй байдал ба эрүүл мэндийн боловсрол эзэмшсэн хүн л чичиргээт багажуудыг ашиглан ажил хийнэ.
2. Аль болох хөнгөн, чичиргээ багатай чичиргээт багажууд сонгоод тогтмол шалгаж арчилна.
3. Чичиргээнээс хамгаалах бээлий болон чихний бөглөөс зэрэг хамгаалах хэрэгсэл ашигла.

(5) Өргөх машин (левотка)


Өргөх машиныг (левотка) материалуудыг өргөх юмуу буулгахад ашиглах бөгөөд буруу ажиллагаа юмуу ажлын үед хайхрамжгүй байсны улмаас осол гарах эрсдэлтэй байдаг.



Анхаарах ёстой зүйл

Өргөх ажлыг “Тусгай боловсрол” эзэмшсэн хүн ажиллуулна.

(6) Цахилгаан өрөм




Цахилгаан өрөм

Анхаарах ёстой зүйл

1. Ирэнд гэмтэл байгаа эсэх свич нь хэвийн ажиллаж байгаа эсэхийг шалга.
2. Өрмийг биеийн урл талд хэрэглэ.
3. Босоо гадаргуу дээр нүх өрөмдөх үед түүний цаана хүн байхгүй эсэхийг нягтал.
4. Ажил хийхдээ материалыг зас.
5. Ашиглах явцад хэвийн бус дуу чимээ юмуу чичиргээ үүсвэл ажиллагааг даруй зогсоо.
6. Хатуу кабелийн утас болон газардуулгын гэмтлийг шалга.
7. Хөдөлж байхдаа өрмийг унтраа.
8. Хэрэглээгүй үедээ залгуураас салга.

(7) Дискэн өнгөлөгч



Анхаарах ёстой зүйл

1. Дискэн өнгөлөгчийг хоёр гараараа чанга атгаад ажиллуулна.
2. Өнгөлөгчийн хүрдийг солих юмуу солих үед туршилтаар ажиллуулахад тусгай боловсрол шаардлагатай.
3. Өнгөлөгчийн хүрдийн хувьд ажил эхлүүлэхээс өмнө хамгийн багадаа 1 минут, хүрдийг больсон тохиолдолд хамгийн багадаа 3 минут туршилтаар ажиллуулна.

(8) Цохилтот өрөм (цохилтот дорцов)



Анхаарах ёстой зүйл

1. Цохилтот өрөм зэрэг цахилгаан багажуудыг ашиглах үед гар хөлөө эргэлдэж байгаа эд анги руу хэзээ тавьж болохгүй.
2. Таны гар өрмийн эргэлдэж байгаа хошуунд (гол) орооцолддог учраас бээлий өмсөж болохгүй.
3. Чичиргээт багаж ажиллуулахтай холбоотой аюулгүй байдал ба эрүүл мэндийн боловсрол эзэмшсэн хүн л цохилтот өрөм зэрэг чичиргээт багажуудыг ашиглан ажил хийнэ.